



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар A/99

Жаргалант

**Малын хөлөөс тариалангийн талбайг
чөлөөлүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 16 дугаар хуралдааны 05 дугаар тогтоолын хавсралт "Малчид, тариаланчдын харилцан үйл ажиллагааг зохицуулах журам"-ын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 онд тариалалт хийсэн Дарцагтын баруун, зүүн, Уртын баруун, Уртын зүүн, Цэнх, Наран, Нарангийн баруун, зүүн, Шанаган булаг, Бэрх, Шаварт, Гүүрний ухаа зэрэг тариалангийн талбайд ойролцоо нутаглаж байгаа малчид 06 дугаар сарын 27-ноос, 10 дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд тариалангийн бүсийг чөлөөлж 5 км-ээс гадагш гарч нутаглахыг үүрэг болгосугай.

2.06 дугаар сарын 15-наас, 10 дугаар сарын 15-ний өдрийг хүртэлх хугацаанд малаа байнгын хариулгатай байлгах, алсын бэлчээрт гаргах, ургацыг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг малчин, мал бүхий иргэдэд анхааруулсугай.

3.Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан тариалан эрхлэгчдийн үүргийг биелүүлж, тариалангийн талбайг байнгын эргүүл хамгаалалттай байлгаж, таримал ургамлын талбайд мал оруулахгүй байх арга хэмжээг авч ажиллахыг газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн захирал нарт үүрэг болгосугай.

4.Тариалангийн тухай хуулийн дагуу тариалангийн талбайгаас 500 метр зайд өвөлжөө хаваржаагаа 2025 оны 06 дугаар сарын 27-ноос 08 дугаар сарын 15-ний дотор нүүлгэн шилжүүлж барихыг малчин, мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

5.Тариалангийн бүсэд байгаа айл өрхөд мэдэгдэж нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Онон багийн Засаг дарга (Э.Бат-Орших)-д үүрэг болгосугай.

6.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж хууль тогтоомж зөрчигчдөд Тариалангийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 13.1.5 дахь заалтын дагуу хариуцлага тооцож ажиллахыг Газар тариалан хариуцсан мэргэжилтэн М.Мөнгөнтуяа, Онон багийн Засаг дарга Э.Бат-Орших нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501225

Handwritten text in red ink, possibly a signature or stamp, located in the bottom left corner.

Handwritten signature or initials in black ink, located in the bottom left corner.

